

Олгий сумын гол гудамжинд гаднаас ороод ирсэн ачаатай КАМАЗ машин гурван хонгон тэргийг дайрч гараад айлын хашаа руу цомрон орсон тухай харсан хүмүүс ярьж байгаа ч цагдаагийнхан энэ талаар тодорхой мэдээлэл, тайлбар огохгүй байна.

Машиныхаа тоормоз бариаггүйгээс хэд хэдэн хүн амь насаа алдсанд харамссан Ховд аймгийн жолооч вйлдсэн хэрэгтээ гэмшсэндээ хоолойгоо огтлон амиа хорлосон гэнэ.

Ачаатай КАМАЗ машин хурд хэтрүүлэхээр тоормоз барьдаггүйн учир энэ мэтийн осол таван жилийн омно энд бас гарсан тухай хүмүүс ярьж байна.

Тус аймагт тээврийн хэрэгслийн тоо 12 500 хүрсэн, согтуугаар машин жолоодож замын ходолгоонд оролцох явдал буурсан ч явган хүний замын хашлагыг давж гарах, техник жолоодох эрхгүй атлаа машин барьж замын ходолгоонд оролцох, хурд хэтрүүлэх зэрэг зорчлоор он гарсаар 3400 орчим зорчил гарч гэмтнүүд нь торгуулсан тухай ходолгооний аюулгүй байдлыг хангах тасгийн дарга А.Ержан ярьж, ходолгоонд соёлтой оролцохыг анхааруулж байна.